



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/188

Номгон

Г "Цахимд хэвшье" DIJITAL FIRST D1 арга  
хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 17/59 дүгээр тогтоолын 2-р хавсралт аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний 208 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Цахим хөгжил харилцаа холбооны яам, И-МОНГОЛ академи УТҮГ, Монголын программ хангамж үйлдвэрлэгчдийн холбоо ТББ хамтран зохион байгуулж буй "Цахимд хэвшье" DIJITAL FIRST D1 арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2."Цахимд хэвшье" DIJITAL FIRST D1 арга хэмжээ болон орон нутгийн онцлогтой төрийн үйлчилгээг цахимд шилжүүлэх, иргэд, төрийн албан хаагчдын тоон бичиг үсгийн чадавхыг нэмэгдүүлэх, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд шаардагдах 18,000,000 (Арван найман сая) төгрөгийг аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3.Тус арга хэмжээг заасан хугацаанд үр дүнтэй зохион байгуулж, мэдээллээр ханган ажиллаж, тайлагнахыг ажлын хэсэг, Төрийн цахим үйлчилгээний хэлтэс (Г.Ганчулуун) -т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

024010405

Аймгийн Засаг даргын .....-ны өдрийн ..... дугаар захирамжийн  
..... дугаар хэвсрэл



ЦАХИМД ХЭВШЬЕ DIGITAL FIRST D1  
АРГА ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН  
ТООЦОО

д/д	Аж ахуй нэгжийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Бүгд үнэ
1	Ажлын хэсгийн хоолны зардал /03.24-03.25/	Хүн	60	7,372,310
2	Ажлын хэсгийн буудлын зардал /03.24-03.25/	Хүн	2	924,400
3	Заалны тохижилтын зардал /ширээний бүтээлэг/	Ширхэг	20	658,000
4	Ус ундаа цайны материал	Хүн	200	1,483,700
5	Хэвлэлийн зардал /Аннос, стэнд, хөөсөн хэвлэл/	Ширхэг	-	3,160,800
6	Цахим үйлчилгээний Смарт төвийн тохижилт	Ширхэг	1	4,400,790
Нийт дүн:				18,000,000

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_